



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.01.08 № 01/33

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулгын хариу хүргүүлэх тухай**

Тус компаниас зарласан ЭТТХК/202301021 дугаартай Нүүрс ачилт буулгалтын талбай буюу гаалийн хяналтын бүсийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн ТШЗ 9.1-д заасны дагуу 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 15 цагт тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдтэй урьдчилсан уулзалтыг зохион байгуулсан. Урьдчилсан уулзалтын үеэр тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдийн тендерийн баримт бичигтэй холбоотой асуусан зарим тодруулгыг Үнэлгээний хороо хуралдан, хэлэлцээд тендерийн баримт бичигт шаардлагатай өөрчлөлтийг оруулсныг хүргүүлж байна. Үүнд:

Тодруулга-1-д: ТШЗ 17.1.6-д “Ижил төстэй ажилд барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн туршлагыг тооцно. Түншлэлийн гишүүд нь түншлэлийн гэрээнд заагдсан гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу ижил төстэй ажил хийж гүйцэтгэсэн туршлагыг тооцно.” гэж нэмэх;

Тодруулга -2-т: ТШЗ 17.6.1-д “ТЗ-2.1 0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ” тусгай зөвшөөрөл нь “БА-3.5” тусгай зөвшөөрөлтэй дүйцнэ” гэж нэмэх;

Тодруулга 3-т: ТШЗ 17.8-д “Тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 20 хүртэл хувь байна.” гэж өөрчлөх;

Тодруулга 4-т: ТШЗ 17.6.2-т “Автозамын инженер нь тухайн ажилд хөлсөөр ажиллах гэрээтэй ажилтан байж болно. Хөлсөөр ажиллах гэрээг ирүүлэх ба гэрээ хэрэгжих хугацаанд хүчинтэй байна.” гэж нэмэх;

Тодруулга 5-д: ТШЗ 17.8-д заасан “Туслан гүйцэтгэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн мэдээллийг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана.” гэснийг хасах гэж тус тус өөрчилсөн болно.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 11.3-т заасны дагуу дээрх нэмэлт, өөрчлөлтүүд нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ  
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ



Ж.ГАНБАТ

0400000973